Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Гадаад хамтын ажиллагааны газар

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 3.1. | Боловсролын салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх, гадаад улсад хүний нөөц бэлтгэх, олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэ | - | - | - | - | | Яамны удирдлагын гадаад, дотоодод хийх айлчлал, уулзалтыг зохион байгуулах хүрээнд Монгол Улсад суугаа Элчин сайд нар болон олон улсын байгууллагын суурин зохицуулагч нартай хийсэн уулзалтын бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн. Тухайлбал, Сайд П.Наранбаярын Оросын шинжлэх ухаан, дээд боловсролын сайд | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | В.Н Фальков, ИБУИНХУ-ын Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Фиона Блайт, АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Ричард Буанган, ХБНГУ-ын Элчин сайдын хэргийг түр хамаарагч Ханна Бэкер, НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч Эваристе Каусси Комлан, НҮБ-ын Хүн Амын Сангийн Тэргүүн Халид Шарифи, НҮБ-ын Хүүхдийн Сангийн Зүүн Ази Номхон Далайн бүсийг хариуцсан захирал Жүни Күнүги нартай хийсэн уулзалт, Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргалын ХБНГУ-ын элчин сайд Хэльмут Кулитц, БНХАУ-ын Боловсролын яамны дэргэдэх “Гадаад улс орнуудад Хятад | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлийг сурталчлах хамтын ажиллагаа, солилцооны төв”-ийн дэд захирал Жин Вэй нартай хийсэн уулзалтын бэлтгэл ханган орчуулга, тэмдэглэл хөтөлсөн. Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн БНХАУ-ын Шанхай хотод хийсэн айлчлал, Дэд сайд Г.Ганбаярын Бүгд Найрамдах Беларусь улсад хийсэн айлчлал, Сайд П.Наранбаярын Япон Улсад хийсэн айлчлалыг зохион байгуулсан. Тайлангийн хугацаанд гадаадын сургалтад 110 багш, албан хаагчийг сургалтад хамруулсан. Мөн энэ хугацаанд Киргиз, ОХУ, Румын, Филиппин, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Чех, Турк зэрэг улсуудтай боловсролын салбарт хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллаж байна. | | |
| 3.1.1 | “Улаанбаатар хотод хамтарсан ерөнхий боловсролын сургалтын байгууллага “Монгол-Оросын хамтарсан ерөнхий боловсролын сургууль” байгуулах, ажиллуулах нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг эцэслэн тохирох | - | Хэлэлцээрийн төсөл | Хэлэлцээрийн төслийг боловсруулсан. | - | Хэлэлцээрийн төслийг эцэслэн тохирсон байна. | Улаанбаатар хотод хамтарсан ерөнхий боловсролын сургалтын байгууллага "Монгол-Оросын хамтарсан ерөнхий боловсролын сургууль" байгуулах, ажиллуулах нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Оросын талтай эцэслэн тохирсон. Оросын талаас хэлэлцээрийн төслийг эцэслэн тохирсон, хэлэлцээрийг байгуулах саналаа | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Боловсрол, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны дэд комиссын XVII хуралдааны протоколын төсөлд тусган ирүүлсэн. /Оросын талаас ирүүлсэн хуралдааны протоколын төсөл/ Хэлэлцээрийн төслийг Оросын талтай эцэслэн тохирох чиглэлээр 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс хойш ажилласан бөгөөд энэ хугацаанд Оросын Холбооны Улсын Боловсролын яамны төлөөлөгчдийг 2024.09.04-07-ны өдрүүдэд хүлээн авч, ажлын түвшний яриа, хэлэлцээний бэлтгэл ханган, орчуулга хийсэн. Оросын талаас ирүүлсэн хэлэлцээрийн төслийг орчуулан Монголын талын хариу төслийг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Оросын талд дипломат шугамаар 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 8/1875 тоотоор хүргүүлсэн. Хавсралт: 4 файл | | |
| 3.1.2 | Боловсролын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулах | - | Хэлэлцээрийн төсөл | - | - | Хэлэлцээрийн төслийг боловсруулан төслийг эцэслэх чиглэлээр ажилласан байна. | Туркийн талаас ирүүлсэн 'Боловсролын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр'-ийн төслийг судалж, удирдлагаас ирсэн чиглэлийн дагуу Монголын талын хэлэлцээрийн хариу төслийг боловсруулсан. Шуурхай байдлыг хангах үүднээс хэлэлцээрийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр ГХЯ-нд цахим шуудангаар | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргүүлсэн. Түүнчлэн Монгол Улсын Боловсролын яам, Гадаад харилцааны яам, Монгол Улсаас Турк Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний боловсролын яам, Маариф сангийн төлөөлөлтэй 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр цахимаар уулзаж, хэлэлцээрийн төслийг эцэслэх чиглэлээр санал солилцсон. Энэхүү хэлэлцээрийн төслийг эцэслэх зорилгоор 2024 оны 12 дугаар сард дахин цахим хурал зохион байгуулахаар талууд тохиролцоод байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 3.1.3 | "Улаанбаатар хот дахь Орос-Монголын | - | Хэлэлцээрийн төслийн орчуулга | - | - | Оросын талаас ирүүлсэн | “Улаанбаатар хот дахь Орос-Монголын ерөнхий | 100% | 100 % |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ерөнхий боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны нөхцөлийн тухай Оросын Холбооны Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулах нөхцөлийг судлах | | | | | хэлэлцээрийн төслийг орчуулж, сургуулийн эзэмшлийн хувийн талаар санал бэлтгэн удирдлагад танилцуулсан байна. | боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны нөхцөлийн тухай Оросын Холбооны Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн Оросын талын ирүүлсэн хэлэлцээрийн төслийн монгол хэл рүү орчуулж дуусгасан. Мөн Ерөнхий сайдын Исламын Бүгд Найрамдах Пакистан Улсад 2024 оны 10 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Засгийн газрын тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд оролцсоны мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд Орос 3 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаар сургуулийн өмчийн эзэмшлийн хувийг 50/50 болгох чиглэлтэй танилцан (ГХЯ-ны 2024.11.12-ны 01/5417 тоот) хариу саналыг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу бэлтгэн хүргүүлэх арга хэмжээг авсан (тус яамны 2024.11.15-ны 1/2226 ).<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.1.4 | “Дээд боловсролын салбарт хамтран ажиллах болон англи хэлний сургалт хамтран зохион байгуулах тухай Монгол Улсын Боловсролын яам, Бүгд Найрамдах Филиппин Улсын Дээд боловсролын хороо хоорондын харилцан | - | Санамж бичгийн төсөл | - | - | Санамж бичгийн төслийг боловсруулсан байна. | Монгол Улсын Боловсролын яам, Бүгд Найрамдах Филиппин Улсын Дээд боловсролын хороо хоорондын Дээд боловсролын салбарт хамтран ажиллах болон англи хэлний сургалт хамтран зохион байгуулах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулсан. Санамж бичгийн төслийг зохих журмын дагуу | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ойлголцлын санамж бичиг”-ийн төслийг боловсруулах | | | | | | ГХЯ-нд 2024 оны 10 сарын 28-ны өдрийн 8/1795 тоотоор хүргүүлсэн. Санамж бичгийн төсөлд Филиппин Улсад ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш нарыг сургах, мөн Филиппинээс англи хэлний багш авч, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудад ажиллуулах тухай саналыг тусгасан. Хавсралт: 2 файл | | |
| 3.1.5 | Яамны удирдлагын гадаад, дотоодод хийх айлчлал, уулзалтыг зохион байгуулах | - | Зохион байгуулсан айлчлал, уулзалтын тоо | - | Айлчлал, уулзалтын бэлтгэл хангаж, чанарын өндөр түвшинд зохион байгуулсан байна. | Айлчлал, уулзалтын бэлтгэл хангаж, чанарын өндөр түвшинд зохион байгуулсан байна. | Яамны удирдлагын гадаад, дотоодод хийх айлчлал, уулзалтыг зохион байгуулах хүрээнд Монгол Улсад суугаа Элчин сайд нар болон олон улсын байгууллагын суурин зохицуулагч нартай хийсэн уулзалтын бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн. | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Тухайлбал, Сайд П.Наранбаярын Оросын шинжлэх ухаан, дээд боловсролын сайд В.Н Фальков, ИБУИНХУ-ын Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Фиона Блайт, АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Ричард Буанган, ХБНГУ-ын Элчин сайдын хэргийг түр хамаарагч Ханна Бэкер, НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч Эваристе Кауcси Комлан, НҮБ-ын Хүн Амын Сангийн Тэргүүн Халид Шарифи, НҮБ-ын Хүүхдийн Сангийн Зүүн Ази Номхон Далайн бүсийг хариуцсан захирал Жүни Күнүги нартай хийсэн уулзалт, Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргалын ХБНГУ-ын элчин сайд Хэльмут | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Кулитц, БНХАУ-ын Боловсролын яамны дэргэдэх “Гадаад улс орнуудад Хятад хэлийг сурталчлах хамтын ажиллагаа, солилцооны төв”-ийн дэд захирал Жин Вэй нартай хийсэн уулзалтын бэлтгэл ханган орчуулга, тэмдэглэл хөтөлсөн. Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн БНХАУ-ын Шанхай хотод хийсэн айлчлал, Дэд сайд Г.Ганбаярын Бүгд Найрамдах Беларусь улсад хийсэн айлчлал, Сайд П.Наранбаярын Япон Улсад хийсэн айлчлалыг зохион байгуулсан. Хавсралт: 7 файл | | |
| 3.1.6 | Бүх түвшний боловсролын байгууллагын | - | Сургалтад хамрагдсан багшийн тоо, | - | Сургалтад багш нарыг хамруулсан | Сургалтад багш нарыг хамруулсан | 1.Боловсрол, шинжлэх ухааны яам, НҮБ-ын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | багш нарыг гадаад улсад туршлага судлах богино, дунд хугацааны сургалтад хамруулах | | зохион байгуулсан арга хэмжээний тоо | | байна. | байна. | Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO)-ын ивээл дор Ази-Номхон далайн орнуудын “Багш солилцоо”-ны хөтөлбөрийг БНСУ-тай хамтран хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 10 багшийг БНСУ-ын сургуулиудад 2024.04.16-ны өдрөөс 3 сарын хугацаатай ажиллуулсан. БНСУ-ын 10 багш нийслэлийн 1, 20, 63, 14 болон 72 дугаар сургуулиудад 2024 оны 3-5 дугаар саруудад ажилласан. Монгол-Солонгосын Багш солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хоёр улсын ерөнхий боловсролын сургуулийн багш | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нар харилцан туршлага солилцох, хоёр улсын түүх соёл, ёс уламжлалаа түгээн дэлгэрүүлэхэд ач холбогдолтой байлаа. 2.БНХАУ-ын ӨМӨЗО-ы Боловсролын танхимын урилгаар Бугат, Хөх-Хот зэрэг хотуудад 01 дүгээр сарын 10-17-ны өдрүүд, мөн 03 дугаар сарын 24-29-ний өдрүүдэд орон нутгийн ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсролын сургуулийн 60 багш, арга зүйч нарыг туршлага солилцох сургалтад хамруулсан. 3.Боловсролын яамны болон ерөнхий боловсролын сургуулийн 40 албан хаагч, багш нарыг Бүгд Найрамдах Турк Улсын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Боловсролын яамны харьяа тусгай боловсролын чиг баримжаа өгөх агентлагт туршлага судлах сургалтад хамруулсан. Түүнчлэн 2024 оны 06 дугаар сард ерөнхий боловсролын сургуулиудын 20 багшийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Дэжон хотноо мэдээлэл, технологийн сургалтад 14 хоногийн хугацаанд хамруулсан. “Цахим сургалтын санаачилгад хамтран ажиллах тухай Монгол Улсын Боловсролын ерөнхий газар болон Арабын Нэгдсэн Эмират Улсын Дижитал сургууль хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүрээнд хэрэгжиж буй "Мэргэшсэн дижитал багш" хөтөлбөрт буюу АНУ-ын их сургуульд цахимаар мэргэшил дээшлүүлэх 50 багшийн суралцуулахаар болоод байна. Дээрх 50 багш нь Мэдлэ цахим сургуулийн зөвлөх, англи хэлний мэдлэгтэй судлагдахууны багш нарыг сонгон нэр дэвшүүлсэн болно. Мэдлэ цахим сургууль нь Монгол Улсын өнцөг булан, тэр дундаа алслагдсан сургуулийн суралцагчдад чанартай сургалтыг тэгш хүргэн ажиллаж байна. | | |
| 3.1.7 | Англи хэлтэй улсын Элчин сайд нарын уулзалтыг зохион байгуулах | - | Арга хэмжээ | - | Уулзалтыг өндөр түвшинд зохион байгуулсан байна. | - | Засгийн газрын тогтоолоор баталсан “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол Улсын англи хэлний боловсролыг сайжруулах хэлэлцүүлэг уулзалтыг Монгол Улсад суугаа АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран хоёр удаа амжилттай зохион байгуулсан. Тус уулзалтад АНУ, Их Британи, Канад, Австрали, Энэтхэг, зэрэг улсын Элчин сайд нараас гадна англи хэлний хөтөлбөрийг дэмждэг Энх тайвны корпус, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Хүүхдийг ивээх сан зэрэг олон улсын байгууллагын удирдлагууд оролцож Монгол Улсад нэвтрүүлж эхэлж буй Англи хэлний хөтөлбөрийн явц, тулгамдаж буй асуудал зэргийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүрээнд санал солилцсон. Уулзалтын үеэр Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хөтөлбөрийн шинэчлэл, сургуулийн болон багшийн үнэлгээ, багшийн чадавх, үр дүнд суурилсан санхүүжилт, сургуулийн менежмент, цахим шилжилт зэрэг боловсролын салбарт хийгдэж буй томоохон зургаан шинэчлэлийн талаар танилцуулга хийсэн. Мөн зөвхөн англи хэл төдийгүй Монгол улсын ерөнхий боловсролын салбарыг олон улсын түвшинд хүргэж дэлхийд өрсөлдөхүйц монгол иргэнийг бэлдэхэд манайд хэрэгжиж эхлээд буй англи хэлний “Pearson”, математикийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Eduten” хөтөлбөр болон цаашид хийхээр төлөвлөж буй ажил, хүрэх зорилгыг танилцуулсан. 2 дох удаагийн уулзалтад Боловсролын сайд П.Наранбаяр оролцож хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн танилцуулгыг хийсэн. Энэхүү уулзалтын мөрөөр Center for Excellence төвийг бий болгох талаар харилцан тохиролцсон. Энэхүү төвийг Монгол Улсын Их сургуулийг түшиглэн АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран ажлын хэсэг гарган ажиллаж байгаа болно<br>Хавсралт: 3 файл | | |
| 3.1.8 | Засгийн газар, яамд | - | Гэрээ, хэлэлцээрийн | Байгуулсан гэрээ, | Гэрээ, хэлэлцээрийн | Гэрээ, хэлэлцээрийн | Засгийн газар, Боловсрол, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хоорондын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд гадаад улсад оюутан суралцуулах үйл ажиллагааг зохион байгуулах | | хүрээнд гадаадад суралцуулахаар илгээсэн иргэдийн тоо | хэлэлцээр | хүрээнд иргэдийг гадаадад суралцуулахаар илгээсэн байна. | хүрээнд иргэдийг гадаадад суралцуулахаар илгээсэн байна. | шинжлэх ухаан яам хоорондын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд гадаад улсад оюутан суралцуулах үйл ажиллагааг зохион байгуулах БШУ-ны сайдын тушаалын дагуу Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр суралцах оюутны тоо 2023 оны байдлаар хийгдсэн гэрээ, хэлэлцээр Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. 2024 онд Засгийн газар хоорондын гэрээний хүрээнд хэрэгжиж буй Бүгд Найрамдах Польш улс, Казахстан улс, Чех, Их Британи, Унгар, Вьетнам, Франц зэрэг улсуудын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, сонгон | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шалгаруулах зар мэдээллийг боловсруулан байршуулж, Боловсролын зээлийн сантай хамтран сонгон шалгаруулалт ирүүлсэн материалын бүрдэл болон эссэг цахим системээр шалгаж холбогдох ЭСЯ-тай хамтран сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Шалгарсан иргэдийн мэдээллийг ЭСЯ-уудад хүргүүлж дараагийн арга хэмжээг авч ажиллаж байна. 2024-2025 оны хичээлийн жилд Бүгд Найрамдах Польш улсад-22, Бүгд Найрамдах Казахстан улсад-11, Бүгд Найрамдах Вьетнам улсад-9, Бүгд Найрамдах Франц улсад-10 оюутан тус тус суралцахаар | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сонгон шалгаруулалатад тэнцсэн. -ОХУ-ын Эрхүүгийн Үндэсний Судалгааны Техникийн Их сургуульд 2024--2025 оны хичээлийн жилд цахилгаан эрчим хүч, усан цахилгаан станц, дулааны эрчим хүчний чиглэлээр бакалаврын сургалтад нийт 30 хүртэл оюутныг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангаж, зарыг байршуулж, бүртгэлийн үйл ажиллагаа үргэжлүүлж байна. -БНХАУ-ын ӨМӨЗО-ны дээд боловсролын байгууллагуудад суралцуулах сонгон шалгаруулалтын талаар мэдээллийг иргэдэд ил тод нээлттэй байршуулж 150 иргэн суралцахаар | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болсон. -ОХУ-ын “Роснефть” Нээлттэй хувьцаат нийгэмлэгийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд И.М.Губкины нэрэмжит Оросын газрын тос, байгалийн хийн их сургууль болон Москвагийн олон улсын харилцааны их сургуулийн бакалаврын сургалтад нийт 10 оюутныг ГХЯ-тай хамтран сонгон шалгаруулсан. Хавсралт: 3 файл | | |
| 3.1.9 | Монгол Улсын Ерөнхий сайдын (Засгийн газрын) тэтгэлэгт хөтөлбөрийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | - | Тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо | 2023 онд тэтгэлэгт хөтөлбөрийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн. | Бэлтгэл ажлыг хангасан байна. | Бэлтгэл ажлыг хангасан байна. | Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан "ГАДААДЫН БОЛОН ДОТООДЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧИД ТЭТГЭЛЭГ, ЗЭЭЛ ОЛГОХ, ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ, | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ"-ын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах холбогдох байгууллагын төлөөллийг хамруулсан 13 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдаар батлуулсан. Үүний хүрээнд сонгон шалгаруулалттай холбогдох бүх ажлыг олон нийтэд нээлттэй ил тод зохион байгуулж баримт бичгийн бүрдэл, ярилцлага гэсэн хоёр шатаар бүртгүүлсэн 59 иргэнээс шаардлага хангасан 21 иргэнд тэтгэлэгийг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | олгосон байна. Хасагдсан иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг тухай бүр Олон нийтийн зөвлөл, Ажлын хэсэгт танилцуулж журмын дагуу шийдвэрлэсэн. Хавсралт: 2 файл | | |
| 3.1.10 | Дэлхийн шилдэг дээд боловсролын сургалтын байгууллагуудад Монгол иргэдийг суралцуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Тухайн онд батлагдсан төсөв | Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо | 2023 онд хөтөлбөр хэрэгжүүлсэн. | Бэлтгэл ажлыг хангасан байна. | Боловсролын сайдын тушаалаар Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр суралцах иргэдийн жагсаалт батлагдсан байна. | Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан "Гадаадын болон дотоод дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадын шилдэг их, дээд сургуульд бакалаврын зэрэгт зээлээр суралцах хөтөлбөрийн сонгон | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шалгаруулалтыг зохион байгуулах холбогдох байгууллагын төлөөллийг хамруулсан 13 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдаар батлуулсан. Үүний хүрээнд сонгон шалгаруулалттай холбогдох бүх ажлыг олон нийтэд нээлттэй ил тод зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтад нийт 132 иргэн оролцож, баримт бичгийн бүрдэл, суралцах чадварын ерөнхий үнэлгээний шалгалтын дүнгээр шаардлага хангасан 70 иргэнд дэлхийн шилдэг их, дээд сургуульд зээлээр суралцуулах шийдвэрийг гаргуулсан. Сонгон | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шалгаруулалтын дүнгээр хасагдсан иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг тухай бүр Олон нийтийн зөвлөл, Ажлын хэсэгт танилцуулж журмын дагуу шийдвэрлэсэн.<br>Хавсралт: 2 файл | | |
| 3.1.11 | Монгол-Солонгосын боловсролын хамтарсан хорооны 4 дүгээр уулзалтыг зохион байгуулах | - | Арга хэмжээ | - | Уулзалт хийх тов, хэлэлцэх асуудлыг Солонгосын талтай тохирсон байна. | Уулзалтыг зохион байгуулсан байна. | Монгол Улс, БНСУ-ын Боловсролын яамд хоорондын Хамтарсан хорооны 4 дэх удаагийн хурлыг 10 дугаар сарын 16-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулж, боловсролын салбарын хүний нөөц, цахим боловсролын чиглэлээр өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн ажлуудыг хэлэлцэн ажиллав. Энэхүү уулзалтын бэлтгэлтэй холбогдуулан Төрийн нарийн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бичгийн даргын А-59 дугаар тушаалаар Хамтарсан хорооны Монгол талын бүрэлдэхүүнийг шинчлэн батлуулсан. Уулзалтаар талууд цаашид хиймэл оюун ухааныг боловсролын салбарт ашиглах талаар туршлага хуваалцаж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр санал солилцож, Монгол Улсын Боловсролын яамны зүгээс Засгийн газрын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөрт орсон багшлах хүний нөөцийг чадавхжуулах, сургуулийн өмнөх, ерөнхий, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | багш нарыг богино хугацааны сургалтад хамруулахад хамтран ажиллах саналыг илэрхийлсэн байна. Мөн ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын сурагч солилцоог идэвхжүүлэн БНСУ-д үйлдвэрлэлийн дадлага хийлгэхэд хамтран ажиллах боломжийг судлах тухай хэлэлцэв. Хавсралт: 4 файл | | |
| 3.1.12 | Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаад улсын иргэдийг Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагуудад Засгийн | - | Гадаадын иргэдэд тэтгэлэг олгох тухай тушаал | Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгийг олгох тухай тушаалыг 2023 онд батлуулсан. | Суралцах гадаад иргэдиН судалгааг холбогдох байгууллагаас авч нэгтгэсэн байна. | Гадаад улсын иргэдэд Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгийг олгох тухай тушаалыг батлуулсан байна. | 1.Польш, Вьетнам, Казахстан улсын тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалыг зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг дүнгээр суралцуулахаар илгээх тухай | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | газрын тэтгэлгээр суралцуулах зохицуулалтыг хийх | | | | | | Сайдын шийдвэрийг батлуулсан. Энэ ажлын хүрээнд Польшид суралцах оюутнуудад сар бүр 400 ам долларын амьжиргааны зардлыг Боловсролын зээлийг сангаас олгох шийдвэрийг гаргуулсан, Вьетнамын тэтгэлэгт хөтөлбөрт тэнцсэн иргэдийг илгээх ажлыг зохион байгуулсан. 2.Мөн гадаад улстай байгуулсан гэрээ хэлэлцээрийн дагуу 2024-2025 оны хичээлийн жилд гадаадын иргэдийг МУИС, ШУТИС, СУИС, ХААИС, АШУҮИС, МУБИС-д суралцах шийдвэрийг батлуулсан.<br>Хавсралт: 2 файл | | |
| 3.1.13 | Монгол Улсын Ерөнхийлөгчий | - | Хөтөлбөрт хамрагдсан | Ерөнхийлөгчийн тэтгэлэгт | Бэлтгэл ажлыг хангасан | Боловсролын сайдын | Монгол Улсын Ерөнхийлөгчийн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | н нэрэмжит тэтгэлэгийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах | | суралцагчийн тоо | хөтөлбөрийг 2023 онд зохион байгуулсан. | байна. | тушаалаар суралцах иргэдийн жагсаалтыг батлуулсан байна. | илгээлт 2100 хөтөлбөрт 2024-2025 оны хичээлийн жилээс хамрагдах иргэдийн нэрсийн жагсаалтыг Сайдын тушаалаар батлуулсан. Суралцах иргэдийг сонгон шалгаруулах, тэнцсэн иргэдэд батламж гардуулах үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн. Хавсралт: 4 файл | | |
| 3.1.14 | Олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх | - | Дэмжлэг үзүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо | - | Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн байна. | Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн байна. | Олон улсын хөгжлийн болон донор байгууллагаас боловсролын салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг уялдуулах, үр дүнтэй хамтын ажиллагаа, түншлэлийг зохицуулах механизм болох Монгол Улсын боловсролыг | 50% | 50% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дэмжих “Олон нийтийн бүлэг” (Local Education Group)-ийг зөвлөлдөх уулзалтыг 2024 онд хоёр удаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Боловсролын салбарт төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжүүдэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсэгт оролцож ажилласан. АНУ-ЭСЯ-тай хамтарч 2024 оноос хамтран хэрэгжүүлж буй "Англи хэлний чадавхийн төв", ИБУИНВУ-ын ЭСЯ-тай хамтарч буй "Бүх нийтийн англи хэлний боловсрол, суралцахуйг дэмжих“ төслийн ажлын хэсгийн нарийн бичгээр томилогдсон ажиллаж, төслийн саналыг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулсан. | | |
| 3.1.15 | ХБНГУ, БНСУ, Япон Улсад инженер, эмч, сувилагч бэлтгэх тухай төслийн саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх, холбогдох зохицуулалтыг хийх | - | Төслийн саналыг дэвшүүлсэн албан бичиг, ярианы сэдэв | Монгол Улсын Ерөнхий сайд ХБНГУ, БНСУ, Япон улсуудад айлчлал хийхдээ инженер, эмч, сувилагч бэлтгэх саналыг өгсөн. | Шинээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг дэвшүүлсэн байна. | Шинээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг дэвшүүлсэн байна. | Монгол улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээний өмнөх Зөвлөлдөх уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхий сайдын Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад хийсэн албан айлчлалын үеэр яригдсан 1000 инженер бэлтгэх асуудлыг тусгаад байна. Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотноо 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын Хамтарсан хорооны VIII хуралдааны | 70% | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд эмч, сувилагч бэлтгэх асуудлыг 2025 онд хэрэгжүүлэхээр тусган оруулаад байна. Боловсролын сайд П.Наранбаяр 2024 оны 11 дүгээр сард Япон Улсад хийсэн ажлын айлчлалын үеэр инженер технологийн дээд боловсрол төслийн хоёрдугаар үе шатыг эхлүүлэх тухай Япон Улсын Боловсролын сайд, ЖАЙКА гийн Тэргүүн дэд Ерөнхийлөгчтэй санал солилцон үргэлжлүүлэхээр тодорхой саналд хүрээд байна<br>Хавсралт: 3 файл | | |
| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 4.2. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн | - | - | - | - | | Нэгжийн албан хаагчид хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах | | | | | | хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнасан. | | |
| 4.2.16 | Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах | - | Тайлан | - | Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнасан байна. | Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнасан байна. | Нэгжийн албан хаагчид хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнасан. | 100% | 100 % |
| 4.3. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | - | - | - | - | | 2024 онд нийт 19 тэтгэлэгийн зарлал мэдээллийг яамны цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулсан. Гадаад улсын тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээллийг олон | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийтэд тэгш нээлттэй мэдээллэх зорилгоор сонгон шалгаруулалтын явцын мэдээллийг Боловсролын зээлийн сангийн цахим хуудсаар дамжуулан дэлгэрэнгүй хүргэдэг болсон. Ингэснээр иргэд тэтгэлэгийн зараас гадна сонгон шалгаруулалтын зохион байгуулалт, явцтай танилцаж байх боломжийг бүрдүүлсэн. Мөн тайлангийн хугацаанд боловсролын салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилт, үр дүн, зохицуулагч нарын мэдээллийг яамны цахим хуудаст байршуулсан. | | |
| 4.3.17 | Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган | - | Яамны цахим хуудаст байршуулсан мэдээ, мэдээллийн | - | Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын | Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын | 2024 онд нийт 19 тэтгэлэгийн зарлал мэдээллийг яамны цахим хуудас | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллах | | тоо | | хүрээнд иргэд, олон нийтэд мэдээлэл хүргүүлсэн байна. | хүрээнд иргэд, олон нийтэд мэдээлэл хүргүүлсэн байна. | болон олон нийтийн сүлжээнд байршуулсан. Гадаад улсын тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээллийг олон нийтэд тэгш нээлттэй мэдээллэх зорилгоор сонгон шалгаруулалтын явцын мэдээллийг Боловсролын зээлийн сангийн цахим хуудсаар дамжуулан дэлгэрэнгүй хүргэдэг болсон. Ингэснээр иргэд тэтгэлэгийн зараас гадна сонгон шалгаруулалтын зохион байгуулалт, явцтай танилцаж байх боломжийг бүрдүүлсэн. Мөн тайлангийн хугацаанд боловсролын салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилт, үр дүн, зохицуулагч нарын мэдээллийг яамны цахим хуудаст | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байршуулсан.<br>Хавсралт: 5 файл | | |

*Үнэлсэн:* .........................

*..........................................* *.........................* */................................./*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*.........................*

*(огноо)*

*Тайлагнасан:* .........................

*..........................................* *.........................* */................................./*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*.........................*

*(огноо)*